



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар A/83

Улаанбаатар хот

“Магадлагч эмчийн дүрэм”-ийг шинэчлэн
батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”, Засгийн газрын 2014 оны “Дүрэм, журам батлах тухай” 354 тоот тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Магадлагч эмчийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Магадлагч эмчийг орон тоогоор ажиллуулж, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /П.Мөнхтулга/-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” A/70 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

МАГАДЛАГЧ ЭМЧИЙН ДҮРЭМ

Баримт бичгийн дугаар: ДРМ-ЭХМТК-01-2021

Баталсан:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАЗРЫН ДАРГА

Д.ЗОРИГТ

Хянасан:

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ТӨВ
КОМИССЫН ДАРГА


П.МӨНХТУЛГА

Боловсруулсан:

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ
ТӨВ КОМИССЫН НАРЫН БИЧГИЙН
ДАРГА

Т.ЛХАГВАДОРЖ

Эх хувь
Хяналттай хувь
Хуулбар ба хяналттай хувь
Хүчингүй хувь





НДЕГ

Магадлагч эмчийн дүрэм

ДРМ-ЭХМТК -01-2021

Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын дэргэдэх ЭХМТК	A/83	2021.06.28	2021.06.28	8

Нэмэлт өөрчлөлтийн тухай мэдээлэл

Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2015.05.22	Дүрэм шинэчлэн батлах тухай	М.Нармандах
Хувилбар 2	2021.05.20	Дүрэм шинэчлэн батлах тухай	Т.Лхагвадорж

Хувилбар 01



НДЕГ

Магадлагч эмчийн дүрэм

ДРМ-ЭХМТК -01-2021

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Магадлагч эмчийн эрх
3. Магадлагч эмчийн үүрэг
4. Хариуцлага

Хувилбар 01





МАГАДЛАГЧ ЭМЧИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий анагаах ухааны дээд боловсрол эзэмшсэн төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын мэргэжилтнийг магадлагч эмч гэнэ.

1.2. Магадлагч эмч нь даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх үйл ажиллагаанд оролцон, хамтын шийдвэр гаргах, эмнэлгийн хуудасны бичилт, олголт болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, Эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллана.

1.3. Магадлагч эмч нь Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм, Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхтэй бол “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм” зэрэг эрхзүйн баримт бичгийг мөрдөн ажиллана.

Хоёр. Магадлагч эмчийн эрх

Магадлагч эмч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

2.1. Магадлагч эмч нь даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг шийдвэрлэхээс татгалзах, санал гаргах, хэлэлцүүлэх;

2.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлал, эмнэлгийн хуудасны бичилт, олголт, мэргэжлээс шалтгаалах өвчний сувиллын үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага, эрүүл мэндийн байгууллагуудад хууль тогтоомжид заасан эрхийн дагуу хяналт шалгалт хийх, зерчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, улсын байцаагчийн акт, дүгнэлт үйлдэх, баримт бичгийн биелэлтийг хангуулах;

2.3. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолт, эмнэлгийн хуудасны бичилт олголттой холбоотой болон даатгуулагч (иргэн)-ийн тэтгэврийн болон эмнэлгийн хувийн хэрэг, хяналтын карт зэрэг эмнэлгийн анхан шатны баримт бичгийг шалгах;

2.4. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг шийдвэрлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, ажлын цаг богиносгох болон эмнэлгийн хуудасны бичилт олголт, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын үйл ажиллагатай холбоотой асуудлаар дараах тайлбар, лавлагаа, баримт бичгийг гаргуулан авах. Үүнд:



- 2.4.1. Ажил олгогчоос даатгуулагчийн ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн нөхцлийн тухай тодорхойлолт;
- 2.4.2. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгоо болон эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө, сэргээн засах эмчилгээ, сувилгаа эмчийн хяналтын талаарх лавлагаа, дүгнэлт;
- 2.4.3. Даатгуулагч (иргэн)-ийн өвчний болон төрөлтийн түүх, сувилуулагчийн түүх, эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлийг нотлох бүртгэл, санхүүгийн болон бусад холбогдох баримт;
- 2.4.4. Гадаад оронд удаан хугацаагаар эмчлүүлж байгаа даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлахаа иргэний хувийн хүсэлт, оршин сууж буй газрын харьяа эмнэлэгт үзлэг, шинжилгээ, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хамрагдаж буй эсэх талаарх эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь, тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газрын тодорхойлолт зэрэг баталгаажуулсан баримт бичиг;
- 2.4.5. Гадаад оронд байхдаа хөдөлмөрийн чадвар түр алдсан болон жирэмсний хяналтад байсан, амаржсан тохиолдолд иргэний хувийн хүсэлт, оршин сууж буй газрын харьяа эмнэлэгт үзлэг, шинжилгээнд хамрагдсан эсэх талаарх эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр зэрэг баталгаажуулсан баримт бичиг;
- 2.4.6. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шийдвэрлүүлэх, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт олголтын хугацаа хэтэрсэн тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааныг нотолсон баримт бичгийг гаргуулан авах;

2.5. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг дараах тохиолдолд тогтоох, сунгахаас татгалзах, цуцлах санал гаргах эрхтэй. Үүнд:

- 2.5.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа биечилэн оролцоогүй;
- 2.5.2. Комиссын болон эмчлэгч эмчийн эмчилгээ, үйлчилгээний зөвлөмж, зааврыг биелүүлээгүй;
- 2.5.3. Нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдаагүй;
- 2.5.4. Эмчийн хяналтад ороогүй;
- 2.5.5. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн;

2.6. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.7. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг дахин магадлах, тэтгэврийг түр түдгэлзүүлэх, хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсний, амаржсаны тэтгэмж олгохоос татгалзах;

2.8. Эмнэлэг хөдөлмөрийн магадлал, хөдөлмөрийн чадвар алдалтын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;

Хувилбар 01

4/7



2.9. Мэргэжлийн сургалтад хамрагдахад харьяалах нийгмийн даатгалын болон холбогдох байгууллагаас дэмжлэг туслалцаа авах;

2.10. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах болон нийгмийн даатгал, нийгмийн халамжийн санг эрсдэлээс хамгаалах чиглэлээр үр дүнтэй, идэвх санаачлага гарган ажиллаж буй магадлагч эмч нь нийгмийн даатгал, эрүүл мэндийн болон бусад байгууллагын шагнал, урамшуулалт авах;

Гурав. Магадлагч эмчийн үүрэг

Магадлагч эмч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;
- 3.2. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцож, хамтын шийдвэр гаргах;
- 3.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг зохион байгуулах;
- 3.4. Эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагааны тайланг улирал тутам хүлээн авч Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор хэлэлцүүлэх;
- 3.5. Орон нутгийн иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг сар бүр тулган нягтлах, мэдээллийг шинэчлэх;
- 3.6. Мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд тогтмол хяналт тавьж, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг ханган ажиллах;
- 3.7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалд илгээх бичгийг Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн бичиж олгох;
- 3.8. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээг сайжруулах талаар санал боловсруулах, шийдвэрлүүлэх;
- 3.9. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны зардлын төсвийг хуульд заасан хугацаанд боловсруулж, санал өгөх;
- 3.10. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин болон хамтарсан магадлалыг зохион байгуулахад оролцох;





- 3.11. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, ижил мэргэжилтний үзлэг хийх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дээд байгууллагын шийдвэрээр сэлгэн ажиллах;
- 3.12. Даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах сэргээн засах үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- 3.13. Хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч (иргэн), түүний гэр бүлд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллах;
- 3.14. Удирдлага болон дээд шатны байгууллагаас өгсөн хууль тогтоомжид нийцсэн үүрэг, даалгаврыг шуурхай биелүүлэх;
- 3.15. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын холбогдох цахим мэдээллийн санг ашиглан даатгуулагч (иргэн)-ийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сувилгаа хийлгэсэн байдалд хяналт тавих;
- 3.16. Хөдөлмөрийн чадвараа хугацаагүйгээр алдсан нь тогтоогдсон даатгуулагч (иргэн)-ийн эрүүл мэндийн байдал, үзүүлж байгаа тусlamж, үйлчилгээний талаарх судалгааг харьяалагдах өрх болон сумын эмчээс хагас, бүтэн жилээр авч, хяналт тавьж ажиллах;
- 3.17. Эмнэлгийн хуудасны бичилт, олголтод цахимаар болон баримт бичигт тулгуурлан хяналт тавих;
- 3.18. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хиймэл эрхтэн, засал эмчилгээний болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын зардал олгох холбогдох баримт бичгийг хянах; /шинээр/
- 3.19. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд цагийн хөлс олгох хурлын тэмдэглэл, ажилласан цагийн бүртгэлд хяналт тавих;
- 3.20. Эмнэлэг хөдөлмөрийн магадлал, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалын үйл ажиллагаа болон эмнэлгийн хуудасны бичилт олголтой холбоотой асуудлаар ажил олгогч, даатгуулагч (иргэн)- аас ирүүлсэн санал, албан бичиг, өргөдөл, гомдол, мэдээллийг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэх;
- 3.21. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны болон тоон тайланг хагас бүтэн жилээр “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д заасан хугацаанд. Төв комисст ирүүлэх, тайлан, мэдээний үнэн зөвийг хариуцах;



3.22. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд цахимаар болон баримт бичигт тулгуурлан хяналт шалгалт хийж, тайланг хагас бүтэн жилээр гарган Төв комисст хүргүүлэх;

3.23. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон актын маягтын зарцуулалтын тайлан болон нүүдлийн хурлын тайлан, төлөвлөгөөг хагас бүтэн жилээр гаргаж холбогдох дүрэм, журамд заасан хугацаанд Төв комисст ирүүлэх;

3.24. Мэргэжлийн сургалтад тогтмол хамрагдах;

3.25. Төрийн албаны болон нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэмжээг чанд мөрдөж ажиллах;

3.26. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, тайлангаар архивын нэгж бүрдүүлэн хуулийн хугацаанд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх;

Дөрөв. Хариуцлага

4.1. Авшилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг даатгуулагч (иргэн)-д шударга, чанартай, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах;

4.2. Албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдолд зохих журмын дагуу мэдэгдэл, тайлбар гаргах;

4.3. Магадлагч эмч нь хуурамч баримт бичиг үйлдэж даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгохыг завдсан, тогтоолгосон, сунгуулсан бол хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.4. Магадлагч эмч нь хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгох, сунгуулах зорилгоор комиссын гишүүдэд хууль бусаар нөлөөлсөн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.5. Нийгмийн даатгалын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрүү бол гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

